



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 1 сарын 28 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Баярын өдрүүдийн үеийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2 дахь заалт, 109 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 385 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд ажиллах коронавируст (Ковид-19) халдварын эсрэг дархлаажуулалтын цэгийн байршил, ажиллах хуваарийг нэгдүгээр, коронавируст (Ковид-19) халдварыг илрүүлэх шинжилгээний цэгийн ажиллах хуваарийг хоёрдугаар, Ковид-19 амбулаторийн ажиллах хуваарийг гуравдугаар, нийслэлийн эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрийн хуваарийг дөрөвдүгээр, харьяа эрүүл мэндийн байгууллагад хяналт тавих албан тушаалтны нэрсийг тавдугаар, мэдээ авах албан хаагчдын нэрс, хуваарийг зургаадугаар, коронавируст халдварын үеийн хэвтэн эмчлүүлэх нийслэлийн ор зохицуулах багийн ажлын хэсгийн хуваарийг долдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Харьяа Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт ДААЛГАХ нь:

2.1. Сар шинийн баяр, амралтын (2022 оны 02 дугаар сарын 02-06-ны өдөр) өдрүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах албан тушаалтныг томилон, байгууллагын үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний талаарх ерөнхий мэдээллийг Нийслэлийн эрүүл мэндийн газраас хяналт тавих албан тушаалтанд өдөр бүр мэдээлэх,

2.2. Баяр, амралтын өдрүүдэд байгууллагын дарга, удирдлагууд харилцаа холбооны бэлэн байдлыг хангаж, утсаа унтраахгүй байх, дуудлага аваагүй нөхцөлд даруй эргэж холбогдох, хотоос удаан хугацаагаар гарахгүй байх, зайлшгүй тохиолдолд газрын удирдлагад мэдэгдэн, орлон ажиллах албан тушаалтныг томилох,

2.3. Дүүргийн эрүүл мэндийн төвүүд мэс засал, гэмтэл, дотор, хүүхэд, шүдний кабинетыг 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 11.00-14.00 цаг, 02 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд 10:00-15:00 цагийн хооронд тус тус ажиллуулах,

2.4. Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төв хоёр кабинетыг 2022 оны 02 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд 09:00-15:00 цагийн хооронд тус тус ажиллуулах,

2.5. Хэвтүүлэн эмчлэх ор бүхий дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүд нийтээр тэмдэглэх баярын болон амралтын өдрүүдэд хүлээн авах, яаралтай тусламжийн тасагт нэмэлтээр эмч, сувилагч, шаардлагатай ажилчдыг томилон ажиллуулж, ачааллыг зохицуулах,

2.6. Өрхийн эрүүл мэндийн төв бүр нэг эмч, нэг сувилагчийг 2022 оны 02 дугаар сарын 02-ны өдөр 11.00-14.00 цаг, 02 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд 10:00-15:00 цагийн хооронд тус тус ажиллуулах,

2.7. Коронавируст халдвар (Ковид-19)-ын үеийн хэвтэн эмчлүүлэх нийслэлийн ор зохицуулах багийн гишүүдийг батлагдсан хуваарийн дагуу ажиллуулах,

2.8. Хүүхдийн амьсгалын замын өвчлөл, томуу, томуу төст өвчин, Ковид-19 халдварын эмчилгээ, асаргааны талаар зөвлөгөө өгөх утсыг 24 цагаар тогтмол ажиллуулах,

2.9. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын цэгийг хавсралтаар баталсан хуваарийн дагуу ажиллуулж, вакцины нөөц болон яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах,

2.10. Коронавируст халдвар илрүүлэх шинжилгээний цэгийг хавсралтаар баталсан хуваарийн дагуу ажиллуулах, шаардагдах хувийн хамгаалах хэрэгсэл, сорьц, оношлуурын нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах,

2.11. Баяр, амралтын өдрүүдэд ажиллах Тандалт, шуурхай хариу арга хэмжээний багийн ажиллах хуваарийг баталж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуур, шатахуун тослох материалын нөөцийг бүрдүүлэх, нэмэлтээр ажиллах хүн хүч, автомашины бэлэн байдлыг хангах,

2.12. Баяр, амралтын өдрүүдэд ковидын амбулаторийг хавсралтаар баталсан хуваарийн дагуу ажиллуулах, шаардагдах хувийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдлыг хангах,

2.13. Ковидын хэвтэн эмчлүүлэх ор хүлээж буй өвчтөнд гэрээр Тусламж, үйлчилгээ үзүүлэх багийн ажиллах хуваарийг орны хүлээгдэлд үндэслэн зохицуулалт хийж ажиллах,

2.14. Коронавирусын халдвар батлагдан гэрийн тусгаарлалтад байгаа иргэдэд тавих хяналтыг эрчимжүүлж, утсаар болон цахимаар тогтмол холбогдож, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх,

2.15. Түргэн тусламжийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун тослох материалын нөөцийг бүрдүүлэх, нэмэлтээр ажиллах хүний нөөц, автомашины бэлэн байдлыг хангах,

2.16. Үндсэн тусламж болон коронавируст халдвартай иргэдийг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлдэг ор бүхий эрүүл мэндийн байгууллагууд орны нөөцийг бэлэн байлгах, төрөлжсөн мэргэшлийн болон гэнэт үүссэн зайлшгүй шаардлагатай эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардагдах иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх, тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангах,

2.17. Болзошгүй гамшиг, байгалийн аюулт үзэгдэл, хордлого, томоохон осол гэмтэл, тусламж, үйлчилгээ болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ноцтой зөрчил гарсан тухай бүр газрын удирдлагад шуурхай мэдээлэх, шаардлагатай хариу арга хэмжээг цаг алдалгүй авах,

2.18. Тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, хүчилтөрөгч, хамгаалах хувцас хэрэгсэл, өвчтөний хоол, хүнсийг хүрэлцэх хэмжээгээр нөөцлөх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, ажилчдын сонор сэрэмжийг дээшлүүлэх,

2.19. Тушаалыг хэрэгжүүлж баяр, амралтын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу амралтыг биеэр эдлүүлэх, батлагдсан төсөвтөө багтаан илүү цагийг тооцон олгох,

2.20. Эрүүл мэндийн яамны 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 5/453 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг нийт эрүүл мэндийн байгууллагын ажилчдад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажиллах.

3. Осол гэмтэл, хоолны хордлого, угаарын хийн хордлого, осголт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийг дэмжих нийтийн эрүүл мэндийн хэлтэс /О.Энхзаяа/-т, Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс /Ш.Тэгшбаяр/-т, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан сурталчилж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Урантүлхүүр/-т тус тус даалгасугай.


4. Баяр, амралтын өдрүүдэд ажиллах эрүүл мэндийн байгууллагын байршил, цагийн хуваарийг ил байрлуулах, холбогдох мэдээ, мэдээллийг нийтэд хүргэхийг Эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудад, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ, байгууллагын цахим хуудсаар дамжуулан сурталчилж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Н.Урантүлхүүр/-т тус тус үүрэг болгосугай.

5. Баяр, амралтын өдрүүдэд хяналтаар болон мэдээ тайлан гаргаж ажилласан албан хаагчдын тайланг авч нэгтгэн удирдлагад танилцуулахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Б.Нинж/, Эрүүл мэндийг дэмжих, нийтийн эрүүл мэндийн хэлтэс /О.Энхзаяа/, Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс /Ш.Тэгшбаяр/-т, тайланг үндэслэн илүү цагийн хөлсийг бодож олгохыг Санхүү хөрөнгө, оруулалтын хэлтэс /П.Алтанзаяа/-т тус тус үүрэг болгосугай.


6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан Орлогч дарга /Л.Зэндмаа/, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан Орлогч дарга /Ж.Отгонболд/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БЯМБАДОРЖ




Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны ...1... дүгээр сарын 28-ны өдрийн
4/48 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(КОВИД-19)-ЫН ЭСРЭГ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЦЭГИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Дүүргийн нэр	Цэгийн нэр, байршил
1.	Багануур	2022 оны 02 дугаар сарын 01, 02, 03, -ны өдөр 10:00-15:00 цагт тухайн өдрийн төлөвлөлтийн дагуу дүүрэг бүрт 1 цэг ажиллана. 2022 оны 02 дугаар сарын 04-06-ны өдөр 10:00-18:00 цагт тухайн өдрийн төлөвлөлтийн дагуу дүүрэг бүрт дархлаажуулалтын бүх цэг ажиллана.
2.	Багахангай	
3.	Баянгол	
4.	Баянзүрх	
5.	Налайх	
6.	Сонгинохайрхан	
7.	Сүхбаатар	
8.	Чингэлтэй	
9.	Хан-Уул	


Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын
2022 оны .1... дүгээр сарын 28 –ны өдрийн
А/8 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



КОРОНАВИРУСТ (КОВИД-19) ХАЛДВАРЫГ ИЛРҮҮЛЭХ
ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

2022 оны 02 дугаар сарын 01-06-ны өдөр 09:00-12:00 цагт			
№	Дүүргийн нэр	Шинжилгээ хийх цэг	Байршил
1.	Баянгол	Эмүжин эмнэлэг	БГД, 8-р хороо, Хөгжил хотхоны урд талд
2.	Баянзүрх	Жанжин соёлын төв ордон	БЗД, 12-р хороо, Япон-Монголын эмнэлгийн урд талд
3.	Сонгинохайрхан	27-р хорооны иргэний танхим	СХД, 21-р хороолол, Орчлон хорооллын замын урд
4.	Сүхбаатар	СБЭМТ-ийн нэг цэг	СБД, СБЭМТ-ийн арын хашаанд
5.	Чингэлтэй	ЧЭМТ-ийн нэгдсэн эмнэлэг	СУИС-ийн урд талд ЧЭМТ-ийн нэгдсэн эмнэлэг
6.	Хан-Уул	ХУЭМТ-ийн Яармаг дахь салбар амбулатори	ХУД-ийн цагдаагийн 2-р хэлтсийн хойд талд


Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 1... дүгээр сарын 22-ны өдрийн
А/48 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



КОВИД-19 АМБУЛАТОРИЙН
АЖИЛЛАХ ХУВААРЬ

2022 оны 02 дугаар сарын 02-06-ны өдөр 10:00-16:00 цагт			
№	Дүүргийн нэр	Амбулатори	Байршил
1.	Баянгол	БГЭМТ-ийн Ахмадын эмнэлэг	БГЭМТ-ийн Ахмадын эмнэлэг
2.	Баянзүрх	БЗЭМТ-ийн салбар амбулатори	Баянзүрх нэгдсэн эмнэлгийн хажууд
3.	Сонгинохайрхан	СХД-ийн 12 дугаар хорооны ӨЭМТ	Мөнгөн гүүр эмнэлгийн хажууд
4.	Чингэлтэй	ЧЭМТ-ийн Хайлаастын хүүхдийн салбар амбулатори	Хайлаастын хуучин эцэст
5.	Хан-Уул	ХУЭМТ	ХУЭМТ-ийн төв байр
6.	Налайх	НЭМТ-ийн халдвартын тасаг	НЭМТ-ийн байр
7.	Багануур	БНЭМТ-ийн халдвартын тасаг	БНЭМТ-ийн байр
8.	Сүхбаатар дүүрэг	СБЭМТ-ийн Сувилал	СБД-ийн Дамбадаржаа сувилалын байр 1 давхар

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 1-р дүгээр сарын 28-ны өдрийн
А/8 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

№	Овог, нэр	Албан тушаал	Хугацаа
1.	Ш.Алтанзул	Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга /99056693/	02.02-ны өдрийн 10.00-20.00 цаг хүртэл
2.	Б.Нинж	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /88303518/	02.03-ны өдрийн 10.00-20.00 цаг хүртэл
3.	О.Энхзаяа	Эрүүл мэндийг дэмжих нийтийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /99094393/	02.04-ны өдрийн 10.00-20.00 цаг хүртэл
4.	Ш.Тэгшбаяр	Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтсийн дарга /99779568/	02.05-ны өдрийн 10.00-20.00 цаг хүртэл
5.	Э.Энхжаргал	Чанарын удирдлага, аюулгүй байдлын хэлтсийн дарга /99045065/	02.06-ны өдрийн 10.00-20.00 цаг хүртэл

Жич. Хариуцлагатай жижүүрээр ажиллаж байгаа хэлтсийн дарга нар нь тухайн өдрийг бүрэн хариуцаж ажиллана.

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн
А/№ дугаар тушаалын тавдугаар хавсралт

**ХАРЬАА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ХЯНАЛТ
ТАВИХ АЛБАН ТУШААЛТНЫ НЭРС**

№	Хяналт тавих байгууллага /дүүргээр/	Хяналт тавих ажилтан	Албан тушаал	Удирдлага, зохион байгуулалтаар хангах албан тушаалтан
2022 оны 02 дугаар сарын 02-ний өдрөөс 06-ны өдрүүдэд				
1.	Нийслэлийн Түргэн тусламжийн төв	Д.Энхтүвшин	Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /99198454/	2022.02.02-ний 10:00 цагаас 2022.02.04-ний 22:00 цаг хүртэл Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан Орлогч дарга Л.Зэндмаа /99287055/
2.	Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв	Т.Жаргал	Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн /99113914/	
3.	Баянгол дүүргийн ЭМТ	Н.Урантүлхүүр	Захиргаа удирдлагын хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч /99108506/	
4.	Чингэлтэй ЭМТ Наркологийн эмнэлэг	Б.Нинж	Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга /88303518/	
5.	Сүхбаатар дүүргийн ЭМТ, НЭ	Н.Долгормаа	Статистик мэдээлэл, цахим эрүүл мэндийн хэлтсийн дарга /99990577/	2022.02.04-ны 22:00 цагаас 2022.02.07-ний 10:00 цаг хүртэл Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан Орлогч дарга Ж.Отгонболд /99112615/
6.	Баянзүрх дүүргийн ЭМТ, НЭ	Э.Энхжаргал	Чанарын удирдлага, аюулгүй байдлын хэлтсийн дарга /99045065/	
7.	Хан-Уул дүүргийн ЭМТ, НЭ	О.Энхзаяа	Эрүүл мэндийг дэмжих нийтийн эрүүл мэндийн хэлтсийн дарга /99094393/	
8.	Сонгинохайрхан дүүргийн ЭМТ, НЭ	Ш.Тэгшбаяр	Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтсийн дарга /99779568/	
9.	Налайх дүүргийн ЭМТ	Б.Алтанзул	Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга /99056693/	
10.	Багануур, Багахангай дүүргийн ЭМТ	П.Алтанзаяа	Санхүү хөрөнгө, оруулалтын хэлтсийн дарга /99059981/	
11.	Сэргээн засах клиник эмнэлэг	Н.Мэндсайхан	Халдварт бус өвчний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /99131552/	
12.	Энэрэл эмнэлэг	Б.Баатарсүх	Эмнэлгийн халдварын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /99063239/	

Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын
2022 оны ...1... дүгээр сарын 28-ны өдрийн
4/18 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС МЭДЭЭ АВАХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРС, ХУВААРЬ

№	Мэдээ авах хугацаа	Мэдээ, тайлангийн төрөл	Мэдээ авах мэргэжилтний нэр	Холбогдох утас	Мэдээ авах хэлбэр
1.	2022 оны 02 дугаар сарын 02-06	1. Бүх нийтээр тэмдэглэх баяр, баярын өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэл "АМ36" маягтын мэдээ	Мэргэжилтэн Б.Энхжаргал	80102551	"АМ36" маягтаар burtgel.moh.mn программд өдөр бүр өглөөний 09:00 цагт мэдээллэх
2.		2.Ковид-19 халдварыг эмчилж буй эмнэлгийн сул орны мэдээ			Мэдээг хүснэгтийн дагуу өдөр бүр өглөөний 09.00 цагт nemg.statistic2020@gmail.com, nemg.statistic2021@gmail.com, цахим хаягаар мэдээллэх
3.		3.Коронавируст халдварыг /Ковид-19/ илрүүлэх шинжилгээний мэдээ,			
4.		4.Коронавируст халдварын /Ковид 19/ шалтгаант нас баралтын мэдээ			
5.	2022 оны 02 дугаар сарын 02-06	5. Дархлаажуулалтын мэдээ,	Мэргэжилтэн У.Наранцэцэг	96652404	Мэдээг хүснэгтийн дагуу өглөө бүр "viber"группээр мэдээллэх
		6. Гэрийн хяналт, эмчилгээний мэдээ	Мэргэжилтэн Д.Цэвэлмаа	91101094	
		7. Батлагдсан болон ойрын хавьтлын тоон мэдээ	Мэргэжилтэн Г.Дашдаваа	88013075	
			Мэргэжилтэн Б.Батцоож	99851206	

Х АЖЛЫН ХЭСГИЙН

Д-19)-ЫН ЭМНЭЛГИЙН ОРНЫ ЗОХИЦУУ
2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН ХУВААРЬ

2022 оны 02 дугаар сар

[illegible]

Дархлаажуулалтын цэгийн төлөвлөлт

№	Дүүрэг	Огноо	Цэгийн нэр	Цэгийн байршил	Ажиллах цаг
1	Багануур	2022 оны 2 дугаар сарын 1, 2, 3-ны өдөр	1-р хорооны Иргэний танхим	Хорооны хурлын танхим	10:00 - 15:00 цаг хүртэл ажиллана.
			3-р хорооны Иргэний танхим	Хорооны хурлын танхим	
			4-р хорооны Иргэний танхим	Хорооны хурлын танхим	
			5-р хорооны Иргэний танхим	Хорооны хурлын танхим	
2	Багахангай	2022 оны 2 дугаар сарын 1, 2, 3-ны өдөр	Эрүүл мэндийн төв	Эрүүл мэндийн төв	
3	Баянгол		8-р хорооны Аминжаргалан ӨЭМТ	3,4 хорооллын Дүүхээ төвийн зүүн талд барилгын материалын чанх ард	
4	Налайх		Эрүүл мэндийн төв	Амбулаторийн 3 давхарт	
5	Сонгино хайрхан		29-р хорооны Ариун энэрэл ӨЭМТ	Москва хороололд дотор	
6	Сүхбаатар		14-р хорооны Өнөр ӨЭМТ	35-р сургуулийн зүүн талд, 6-н буудалд төв замын хажууд	
7	Чингэлтэй		Эрүүл мэндийн төв	ЭМТ-ийн 1 давхарт 110 тоотод	
8	Хан-уул		Хан-Уул Ажилчдын соёлын ордон	20 хороо, 19-ын автобусны буудлын урд	
9	Баянзүрх	2022 оны 2 сарын 01-нд	1-р хорооны Иргэний танхим	Сансарын тунел, Хүрмэн эмийн сангийн баруун талд	
		2022 оны 2 сарын 02-нд	4-р хорооны Иргэний танхим	Жуковын автобусны буудлын хойд талд	
		2022 оны 2 сарын 03-нд	25-р хорооны Иргэний танхим	Шинэ монгол сургуулийн ард талд	
9	Нийт				

2 сарын 01, 02, 03-ны өдөр Улаанбаатар хотод 12 суурин цэгээр нийт 12 багийн 48 эмч, ажилчид дархлаажуулалтын үйл ажиллагааг зохион байгуулна.



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, <http://www.mohs.mn>

2022.01.28 № 51453.

танай _____-ны № _____-т

Сар шинийн баярын үеэр эмнэлгийн
тусламж үйлчилгээний бэлэн байдлыг
ханган ажиллах тухай

Сар шинийн баяр, амралтын өдрүүдэд иргэдэд шаардлагатай эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй чанартай, хариуцлагатай үзүүлэхийг анхааруулж дараах зөвлөмж, чиглэлийг хүргүүлж байна.

Нэг: Зохион байгуулалтын талаар

1. Сар шинийн баярын амралтын өдрүүдэд эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчилгээний ажилтны анхаарал сулрах, хариуцлага алдах, ажлын байрыг орхиж явах, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчлийг гаргахгүй байх, байнгын хяналт тавьж ажиллах;
2. Хариуцлагатай жижүүр хийх алсын дуудлаганд явах эмч, сувилагч, бусад мэргэжилтэн, туслах ажилтнуудын хуваарийг батлан, хуваарийн дагуу бэлэн байлгах;
3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдалтай уялдуулан хариу арга хэмжээний бэлэн байдлыг шуурхай хангах, халдварын сэргийлэлт, хяналт, тандалтыг өндөржүүлж, хариуцлага, сахилга бат, дэг журмыг чанд сахих;
4. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнууд амралт, баяр, ёслолын өдрүүдэд гар утсаа нээлттэй байлгах;
5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл, шатлал болон эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх болон асуудлыг шуурхай зохион байгуулах;
6. Болзошгүй гамшиг, осол, хордлого, онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах;
7. Эмнэлгийн яаралтай тусламж, сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг нэгжийн ор, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллах

Хоёр: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний найдвартай тасралтгүй байдлыг хангах талаар:

1. Баярын өдрүүдэд хүндэрсэн, хүндэрч болзошгүй өвчтөн, эх, хүүхдэд тусламжийг шуурхай үзүүлэх, дуудлагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлэн байлгах;

144220827


2. Эх, нярай хүндэрсэн үед ЭХЭМҮТөвөөс хөдөө орон нутаг, алслагдсан хүн амд үзүүлэх алсын дуудлагын үйлчилгээний бэлэн байдлыг хангах, шуурхай зохион байгуулах;
3. Баярын үеэр төрөх тасагт ажиллах жижүүрийн эмчийн хуваарийг зөв зохистой байдлаар гаргаж, туршлагатай эх барих эмэгтэйчүүдийн эмч нарыг ээлжээр жижүүрт гаргах, хариуцлагатай жижүүр, алсын дуудлаганд явах эмч нарыг батлагдсан хуваарийн дагуу бэлэн байлгах; (туршлага багатай залуу эмч нарыг дагнаж жижүүрт гаргахгүй байх)
4. Эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөөнийг хугацаа алдалгүй хийж, шаардлагатай тохиолдолд өвчтөнийг шилжүүлэх ажлыг чирэгдэлгүй, аюулгүй шуурхай зохион байгуулах;
5. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд эмнэлзүйн чиглэлээр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг лавлагаат тусламж үйлчилгээ, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллах;
6. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний эмнэлзүйн заавар, стандартыг чанд мөрдөх, аюулгүй ажиллагааг хангах;
7. Зайлшгүй шаардлагатай яаралтай тусламжийн эм, тариа, ороох боох материал, цус, цусан бүтээгдэхүүний бэлэн байдлыг тогтвортой хангах;
8. Яаралтай тусламжийн тасгаар ирсэн өвчтөнд бүрэн үзлэг хийж, оношилгоо, эмчилгээний асуудлыг шийдвэрлэх, хэвтэн эмчлүүлэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд зөвлөгөө өгч буцаах;
9. Үйлчлүүлэгч, ялангуяа жирэмсэн эмэгтэй аливаа эмнэлэгт хандсан тохиолдолд тусламж, үйлчилгээг хугацаа алдалгүй, шуурхай үзүүлэх, эмнэлэг хооронд явуулж чирэгдүүлэхгүй байх;
10. Хяналтад байгаа жирэмсэн эмэгтэйчүүд ялангуяа өндөр эрсдэлтэй жирэмснийг дуудаж үзэж, жирэмсний аюултай шинж, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд эмнэлэгт хэвтүүлэх;
11. Алсын болон ойрын түргэн тусламжийн дуудлаганд явах унааг бэлэн байлгах, шатахууныг хангалттай хэмжээгээр нөөцлөх;
12. Жирэмслэлт төрөлттэй холбоотой дуудлаганд тусламжийг шуурхай үзүүлэх, шалтгаан тодорхойгүй хэвлийн өвдөлттэй, хордлоготой, дайрлагын байдалтай нөхөн үржихүйн насны эмэгтэйд “Жирэмсний сорил”-ыг заавал тавьж, жирэмсэн эсэхийг тогтоож, шаардлагатай арга хэмжээг шуурхай авах;
13. Хүндэрсэн жирэмсэн эмэгтэй, хүнд өвчтөнд онцгой анхаарал хандуулж анх очсон эмнэлэг, тусламж, үйлчилгээг харъяалал харгалзахгүй үзүүлэх, эмнэлэг хооронд шилжүүлж, чирэгдүүлэхгүй байх, шаардлагатай тохиолдолд эмч нарын зөвлөгөөнийг шуурхай зохион байгуулах;
14. Хяналтын хугацаандаа ирж үзүүлээгүй жирэмсэн эмэгтэйчүүдийг баярын өмнө заавал дуудаж үзэх;
15. Төрөх дөхсөн эмэгтэйчүүдийг эхийн амрах байранд урьдчилан авчирч, гарч болох эрсдлээс сэргийлэх;
16. Отор нүүдэл хийж яваа малчдад эмнэлгийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх, ялангуяа жирэмсэн эмэгтэй хөхүүл эхчүүд, хүүхдийн тусламж үйлчилгээнд онцгой анхаарал хандуулж тэдэнд учирч болох эрсдлээс сэргийлэх, хяналтыг тогтмолжуулах;

17. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн аймаг, сумдын хүн амд онцгойлон анхаарч, осол гэмтэл, хөлдөлт, осголтоос сэргийлэх, жирэмсэн эх, бага насны хүүхдийг асран хамгаалах хүнгүйгээр гэртээ орхихгүй байх чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгөх;
18. Хоолны хордлого, осол гэмтлээс сэргийлсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээж, албан байгууллага, аж ахуй нэгжүүдэд өөрсдийн ажилтнуудаа эрсдлээс сэргийлсэн сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгөхийг анхааруулах;
19. Нийтийг хамарсан хордлого, осол гэмтэл, халдварт өвчний дэгдэлт болон эмнэлгийн тусламж үйлчилгээний ноцтой алдаа, зөрчил гарсан үед Эрүүл мэндийн яамны хариуцлагатай жижүүрт шууд мэдээлнэ. Утас: 11-323002

Гурав. Сар шинийн баярын хариуцлагатай жижүүрийн мэдээний урсгал:

1. Эрүүл мэндийн байгууллага нь сар шинийн баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулах;
2. Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүр харьяа байгууллагын мэдээг авч, нэгдсэн дүнг Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн хариуцлагатай жижүүрт ирүүлэх;
3. Эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар батлагдсан АМ-36 маягтын дагуу мэдээг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх;
4. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь ирүүлсэн мэдээг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд ирүүлэх;
5. Эрүүл мэндийн яамны 24 цагийн турш мэдээ хүлээж авах утасны дугаар 11-323002, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хариуцлагатай жижүүрийн утас 70128801;
6. Эрүүл мэндийн байгууллага хариуцлагатай жижүүрийн нэрс, утасны дугаар тогтмол нээлттэй байх цахим хаягийг ЭМЯ, ЭМХТ-д урьдчилан ирүүлэх;
7. Зайлшгүй шаардлагаар асуудал хариуцсан мэрэгжилтнийг дуудах, аппаратыг бүрэн бүрэлдэхүүнээр яаралтай цуглуулах шаардлагатай гэж үзвэл удирдлагад танилцуулан шийдвэр авч, шуурхай зохион байгуулах

САЙД



С.ЭНХБОЛД